

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны... дугаар сарын.....өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ

Газрын төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 182 дугаар тогтоолд доор дурдсан өөрчлөлт оруулсугай:

1.1.Тогтоолын 2 дахь хэсгийн “.... хот, тосгон, бусад суурины нэг га газрын төлбөрийн хэмжээг түүний суурь үнэлгээний 0.1-1.0 хувь” гэснийг “.... хот, тосгон, бусад суурины нэг га газрын төлбөрийг болон” гэж өөрчлөн найруулсугай.

2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад байгаа газрын төлбөрийг тооцож, ногдуулалт, нэхэмжлэл үүсгэхэд хяналт тавьж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай)-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.УЧРАЛ